

БАТЛАВ:

**“ЮНАЙТЕД КАРЬЕР КОНСАЛТИНГ”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**



Д.ЕРӨӨ

БАТЛАВ:

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА**



Г.ЧИНЗОРИГ

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2021 оны 06-р сарын 14-ны өдөр

ХНҮТ21/10

Улаанбаатар хот

ГЗ/2126

Энэхүү гэрээг /цаашид “Гэрээ” гэх/ Монгол Улсын холбогдох хуулиудыг үндэслэн,
Нэг талаас Монгол улсын хуулийн этгээд болох **“ЮНАЙТЕД КАРЬЕР
КОНСАЛТИНГ” ХХК** /Улсын бүртгэлийн 9011659137, *регистрийн* 6230709
дугаартай, УБ хот, СБД-ийн 1-р хороо, Жамьян гүний гудамж, Чандмань төв, 404
тоот хаягт байрлах /түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Д.Ерөө, /цаашид
“Гүйцэтгэгч” гэх, /хамтад нь “Талууд” гэх/

Нөгөө талаас: Монгол улсын хуулийн этгээд болох **Харилцаа холбооны
зохицуулах хороо** түүнийг төлөөлж Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны
газрын дарга З.Эрдэнэчулуун /цаашид “Захиалагч” гэх/, нар нь дор дурдсан
нөхцлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд захиалагчийн захиалгын дагуу ажилтны хандлага, ур чадварыг тодорхойлох үнэлгээ, менежерийн ур чадварыг тодорхойлох үнэлгээ, сэтгэл хөдлөлөө удирдах оюуны чадамжийг тодорхойлох үнэлгээ /EQ/, авьяасын олон хүчин зүйлийн зураглал /Talent Map/, үнэлгээний үр дүнгийн зөвлөгөө өгөх, ажилтнуудын үнэлгээний үр дүнд тулгуурлан сургалтын хэрэгцээг тодорхойлж, түүнээс нэн тэргүүнд шаардлагатай байгаа сургалтыг ажилтнуудад орох бөгөөд захиалагч нь гэрээнд заасан ажил үйлчилгээний хөлсийг энэ гэрээнд тохиролцсон хэлбэр, хугацаанд гүйцэтгэгчид төлөх, талуудын гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, хүлээх хариуцлагатай холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Гүйцэтгэгч нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн өндөр ур чадвар, ажлын арвин дадлага туршлагатай бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу ажил, үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
- 1.3 Гүйцэтгэгч нь ажил үүргээ гүйцэтгэх хугацаандаа боловсруулсан, бэлтгэсэн, олж авсан, эсвэл ажлын шаардлагаар түүний эзэмшил, ашиглалтад шилжүүлсэн бүх баримт бичиг, мэдээлэл нь түүний зохиогчийн эрх нь Захиалагчийн өмч байна.
- 1.4 Захиалагч нь гэрээнд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “ажил” гэх) 19,860,750 (арван есөн сая найман зуун жаран мянга долоон зуун тавь) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн үнийг үүгээр хүлээн зөвшөөрөв.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.



ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Энэхүү гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа нь талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар эхэлж, талууд хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл үргэлжилнэ.
- 2.2 Гэрээгээр хийх ажил нь **2021 оны 06 дүгээр сараас эхлэн 14-ны өдрөөс эхлэн хуанлын 90 хоногийн хугацаанд үргэлжлэх** ба гэрээний үр дүнг харгалзан хугацааг сунгах боломжтой байна.
- 2.3 Гэрээний хугацаа дуусгавар болох болон гэрээг цуцлахад талуудын гэрээнээс үүдэлтэй гомдлын шаарлага гаргах эрх, үүргийн гүйцэтгэлийг хангах үүргээс бусад эрх, үүрэг дуусгавар болно.
- 2.4 Гэрээний хугацаанд талуудын өмчлөгч, эзэмшигч болон удирдлага өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран гэрээ нь хүчин төгөлдөр хэвээр байна.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР

- 3.1 “Гүйцэтгэгч” нь Хавсралт 1-д заасан ажлын даалгаварын дагуу ажил үүргийг гүйцэтгэнэ.
- 3.2 “Гүйцэтгэгч” нь Хавсралт 2-д заасан Захиалгын хуудасны дагуу ажил үүргийг гүйцэтгэнэ.
- 3.3 Тус гэрээ нь 90 хоногийн хугацаанд үргэлжлэх ба “Захиалагч” байгууллага Хавсралт 3-д тусгасан 30 хувийн хөнгөлөлтийг эдлэх болно.
- 3.4 Гүйцэтгэгч тал нь нийт үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх дүнг үйл ажиллагааг эхлүүлж, эхлэлтийн тайланг ирүүлснээс хойш ажлын 3 хоногийн дотор төлнө.
- 3.5 Гэрээний үнийн дүнгийн 40 хувьтай тэнцэх дүнг захиалагч явцын тайланг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор төлнө.
- 3.6 Гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл 30 хувьтай тэнцэх дүнг захиалагч ажлыг бүрэн хүлээн авсны дараа буюу тайлангийн акт хүлээн аван үйлдсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор төлнө.
- 3.7 Захиалагч нь санхүүгийн нэхэмжлэхийг ажлын 3 хоногийн дотор хянаж ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй бол ийнхүү хянаснаас хойш гэрээнд заасан хугацаанд төлбөрийг Гүйцэтгэгч талын Худалдаа Хөгжлийн банкны 410070954 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.
- 3.8 Гүйцэтгэгчээс ирүүлсэн санхүүгийн нэхэмжлэхэд зөрүүтэй байдал гарвал Захиалагч нь энэ тухай гүйцэтгэгчид мэдэгдэж талуудын төлөөлөл холбогдох баримтыг үндэслэн хамтран хэлэлцэж тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулна.
- 3.9 Гэрээнд заасан төлбөрийг шилжүүлэх санхүүгийн үндсэн баримт нь дүгнэлт болон ажил дүгнэсэн тухай акт, санхүүгийн нэхэмжлэх байх бөгөөд, эдгээр баримт бүрдээгүй тохиолдолд Захиалагч нь ямар нэгэн алданги, торгууль, төлбөр төлөх үүрэг хүлээхгүй.
- 3.10 Төлбөр хийх өдөр нь амралтын өдөр, нийтээр амрах баяр ёслолын өдөртэй давхацсан тохиолдолд дараагийн эхний ажлын өдөр төлбөрийг төлнө.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

- 4.1 Гүйцэтгэгч талын эрх:
 - 4.1.1 Захиалагч талаас төлбөрийг хугацаандаа төлөхийг шаардах эрхтэй.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

- 4.1.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг захиалагч талаас шаардах эрхтэй.
 - 4.1.3 Захиалагч тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол гэрээг дангаар цуцлах, учирсан хохирол зардлыг нэхэмжлэх эрхтэй.
 - 4.1.4 Энэхүү гэрээгээр болон хуулиар олгогдсон бусад эрхийг эдлэх;
- 4.2 Гүйцэтгэгч талын үүрэг:
- 4.2.1 Хамтран ажиллах гэрээний хүрээнд хийгдэх ажлуудыг тусгасан төлөвлөгөөний дагуу хугацаанд нь, чанартай гүйцэтгэх.
 - 4.2.2 Үнэлгээний хэвийн, найдвартай, тасралтгүй, аюулгүй ажиллагаатай байдлыг хангах талаар өөрсдийн нөөц боломжийг бүрэн дайчилж ажиллах.
 - 4.2.3 Захиалагчийн хүсэлтийн дагуу тайланг Англи, Монгол хувилбарын дагуу илгээх.
 - 4.2.4 Захиалагчаас ирэх гомдол саналд түргэн шуурхай хандах, шийдвэрлэх.
 - 4.2.5 Захиалагчаас ирсэн Захиалгын хуудасны дагуу үнэлгээний хуваарийн дагуу үнэлгээний урилгыг илгээх.
 - 4.2.6 Хүний нөөцийн ур чадварын үнэлгээний талаарх хувь хүний аливаа мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглох.
 - 4.2.7 Захиалагчийг тогтмол мэдээллээр хангаж, долоо хоногт 1-2 холболтыг заавал хийх.
 - 4.2.8 Хамтын үйл ажиллагааны хүрээнд харилцагч талын нэгжийн удирдлагуудад хүний үнэлгээний тайланг унших талаар сургалтыг зохион байгуулах үүрэг хүлээх.
 - 4.2.9 “Гүйцэтгэгч” нь “Захиалагч” талыг албан ёсоор төлөөлөхөөр гэрээнд тусгагдсан албан тушаалтанд хамтын ажиллагааны хүрээнд үнэлгээтэй холбоотой тайлан мэдээллийг албан ёсны мэйл хаягаар илгээх.
 - 4.2.10 энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх болон хуульд заасан холбогдох бусад үүргүүдийг хүлээнэ.

ТАВ. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Захиалагч талын эрх:
 - 5.1.1 Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
 - 5.1.2 Энэхүү гэрээгээр болон хуулиар хүлээсэн бусад эрхийг эдэлнэ.
- 5.2 Захиалагч талын үүрэг:
 - 5.2.1 Энэхүү гэрээгээр заасан хугацаанд төлбөрийг төлөх үүрэгтэй.
 - 5.2.2 Үнэлгээнд хамрагдах мэдээллийг Гүйцэтгэгчээс өгсөн Захиалгын хуудасны дагуу бөглөн албан и-мэйлээр илгээж, үйлчилгээний захиалгыг баталгаажуулах.
 - 5.2.3 Менежерийн ур чадварыг тодорхойлох үнэлгээ, Сэтгэл хөдлөлөө удирдах оюуны чадамжийг тодорхойлох үнэлгээнүүд нь олон нийтийн таашаалд нийцүүлж хариулсан эсэхэд тавигдах шалгуур оноотой байдаг бөгөөд зөвшөөрөгдөх дундаж оноог давсан тохиолдолд дахин нэг удаа үнэ төлбөргүй үнэлгээ өгөх эрхтэй.
 - 5.2.4 Олон нийтийн таашаалд нийцүүлж хариулсан эсэхэд тавигдах шалгуур оноог давсан тохиолдолд үнэлгээний тайлан хүчингүйд тооцогдоно.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

“Захиалагч” тал зөвхөн Англи тайланг архив болгон хадгалах боломжтой.

- 5.2.5 Үнэлгээнд хамрагдаж буй ажилтнуудыг “Ажилтнуудад өгөх зөвлөмжтэй” заавал танилцуулж, үнэлгээг бөглүүлсэн байна.
- 5.2.6 Үнэлгээний үр дүнг бодитой гаргахын тулд багийн сэтгэл зүйг үнэлгээнд хамрагдахаас өмнө бэлтгэх, ажилтнуудад сэтгэл зүйн дарамт үзүүлэхгүй байх.
- 5.2.7 Үнэлгээний урилга болон үнэлгээний үр дүнгийн тайланг хүлээн авах албан тушаалтныг хариуцсан нэгжээс томилох.
- 5.2.8 “Гүйцэтгэгч” талаас Хүний нөөцийн ур чадварын үнэлгээний талаарх хувь хүнтэй холбоотой аливаа мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх.

ЗУРГАА. НУУЦ ХАДГАЛАХ ҮҮРЭГ БА БУСАД ХАРИУЦЛАГА

- 6.1 Харилцагч байгууллагын ажилтан болон ажил горилогчдын дата мэдээлэл нь Олон Улсын “Central test” компанийн нууцлалын системээр хамгаалагдаж, хадгалагддаг.
- 6.2 Энэхүү гэрээний аль нэг тал нь нөгөө талын бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр гэрээг байгуулах, хэрэгжүүлэх явцад олж мэдсэн буюу илэрхий болсон Хувь хүний нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар хамгаалагдсан нөгөө талынхаа нууцад хамаарах аливаа мэдээ мэдээллийг бусдад задруулах, түүнчлэн аливаа зорилгоор өөртөө ашиглахыг хориглоно.
- 6.3 Энэхүү гэрээний аль нэг тал нь нөгөө талынхаа нууцад хамаарах мэдээ, мэдээллийг хугацаагүй хадгалах ба санаатайгаар эсвэл санамсаргүйгээр задруулснаар нөгөө талд материаллаг болон материаллаг бус хохирол учирсан бол зөрчил гаргасан тал нь тухайн зөрчлийн улмаас үүссэн бүхий л үр дагаврыг бүрэн хариуцаж, учруулсан хохирлоо бүрэн барагдуулна.
- 6.4 Нууц хадгалах үүрэг зөрчигдсэн гэж үзэхгүй нөхцөл. Монгол улсын хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас гаргаж өгөхийг шаардсан, хуулиар нууцлахыг хориглосон мэдээ, мэдээлэл болон нэгэнт олон нийтэд ил болсон мэдээ, мэдээллийн хувьд нууц хадгалах үүрэг хүлээхгүй.
- 6.5 Хэрэв төрийн эрх бүхий байгууллагаас хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд зөвлөхөөс үйлчлүүлэгчийн талаар мэдээлэл гаргаж өгөхийг шаардвал зөвлөх нь энэ талаар үйлчлүүлэгчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 6.6 Талуудын аль нэг нь нөгөө талын өмнөөс гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй.
- 6.7 Аль нэг талын буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө талд хохирол учирвал гэм буруутай тал түүнийг бүрэн хариуцаж барагдуулна. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас учирсан хохирол болон түүнтэй холбоотой бусад хохирлыг тухай бүр хуульд заасны дагуу хариуцна.

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 7.1 Талуудын хооронд энэхүү Гэрээний зүйл, түүнийг тайлбарлах болон түүний хүчин төгөлдөр байдалтай холбоотой аливаа маргаан эсхүл зөрүү үүссэн

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

тохиолдолд талууд уг маргаан, асуудал эсхүл зөрүүний талаар харилцан тохиролцоонд хүрэхийн тулд боломжит бүх хүчин чармайлтыг гаргана. Талууд гучин (30) өдрийн дотор эсхүл өөрөөр тохиролцсон хугацаанд шийдвэрт хүрч чадаагүй бол аль нэг тал нь нөгөө талдаа бичгээр мэдэгдэл өгөх замаар уг маргаан, нэхэмжлэл, асуудал эсхүл зөрүүг Монгол Улсын холбогдох шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

- 7.2 Талууд харилцан бие биедээ гаргасан гомдлын шаардлага, санал хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5/тав/ хоногийн дотор хянан үзэж, хариу өгөх үүрэгтэй.
- 7.3 Энэхүү гэрээний хугацаа тоолох асуудлаар талуудын хооронд ойлголтын зөрүү буюу маргаан үүсвэл Монгол Улсын Иргэний хуулийн 8/найм/ дугаар бүлэгт заасан журмыг баримтална.
- 7.4 Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, компанийн тамгатай албан бичгийг хүргүүлсэн /гардуулсан/-г “бичгээр мэдэгдсэн” гэж үзнэ.
- 7.5 Гэрээний аль нэг тал үүргээ биелүүлээгүй болон, зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд нэг талын санаачилгаар гэрээг цуцалж болно.
- 7.6 Энэхүү гэрээнд заагаагүй бусад ямарваа үндэслэл шалтгаанаар гэрээний хугацааг цуцлах буюу хүчингүйд тооцохгүй.

НАЙМ.МЭДЭГДЭЛ

- 8.1 Талууд нь энэхүү гэрээний дагуу нөгөө талд хүргүүлэх аливаа мэдэгдэл, шаардлага болон бусад захидал харилцааг бичгээр үйлдэж, дор дурдсан харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан нөгөө талд албан байдлаар хүргэнэ. Энд дурдсан аль нэг талын мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

(1) Гүйцэтгэгч талаас мэдээлэл хүлээн авах албан ёсны хаяг:

Бодлогын хэмжээний асуудал: Гэрээний нөхцөл, хүлээсэн үүрэгтэй холбоотой зөрчил, үнэлгээний үр дүнтэй холбоотой томоохон асуудал, масс үнэлгээ хийлгэх, ашиглалтын талаарх зөвлөгөө, уулзалтын тов, сургалт, төлбөр тооцоо гэх мэт.

- a. Мэдээлэл хүлээн авах албан тушаалтан: Хүний нөөцийн үнэлгээний төвийн захирал О. Дүүриймаа
- b. Утас: 88883455
- c. Үйл ажиллагаа явуулж буй хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж, “Чандмань” төв, 401 тоот
- d. И-мэйл хаяг: duurii.hrac@gmail.com

Үйл ажиллагаатай холбоотой асуудал: Захиалга баталгаажих, эрх нээх, үнэлгээний бөглөлтийн явц, үнэлгээний үр дүнтэй холбоотой жижиг алдаа, өдөр тутмын харилцаа, санал хүсэлт гэх мэт.

- a. Мэдээлэл хүлээн авах албан тушаалтан: Хүний нөөцийн үнэлгээний төвийн байгууллага хариуцсан менежер Б. Мөнхцэцэг
- b. Утас: 93021221
- c. Үйл ажиллагаа явуулж буй хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж, “Чандмань” төв, 401 тоот
- d. И-мэйл хаяг: munkhtsetseg.hrac@gmail.com

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу харьцуулага хүлээлгэх болно.

(2) Захиалагчийн зүгээс мэдээлэл хүлээн авах албан ёсны хаяг:

- a. Мэдээлэл хүлээн авах албан тушаалтан: Хүний нөөцийн мэргэжилтэн Б.Ундармаа
- b. Утас: 88888278
- c. Үйл ажиллагаа явуулж буй хаяг: Метро бизнес төв, А блок 5 давхар Д.Сүхбаатарын гудамж-13, Сүхбаатар дүүрэг, УБ14201-0033
- d. И-мэйл хаяг: undamaa@crc.gov.mn

ЕС. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 9.1 Холбогдох хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 9.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 9.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.
- 9.4 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн нь талуудын эрх ашгийг хөндөхгүй бол тухайн хүчин зүйлийн нөлөөлөл арилах хүртэлх хугацаагаар үүргийн гүйцэтгэлийг хойшлуулж болно.

АРАВ. БУСАД НӨХЦӨЛ

- 10.1 Эрх шилжүүлэх. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу хүлээх аливаа эрх, үүргийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн Үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлэх эрхгүй. Энэхүү гэрээ нь энд дурдсан асуудалтай холбоотой хоёр талын бүхий л харилцан ойлголтыг бүрэн илэрхийлж байгаа бөгөөд, үүнээс өмнө шууд болон шууд бусаар, бичгээр болон амаар хийгдсэн бүх гэрээ, хэлэлцээ, амлалт, баталгаа (хэрэв тийм зүйл байсан бол)-аас давуу хүчинтэй байх болно.
- 10.2 Гэрээний гүйцэтгэлийн явцад аль ч тал нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэж болох ба саналыг хүлээн авсан тал ажлын 3-аас дээшгүй хоногийн дотор нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаар өөрийн саналыг хариу мэдэгдэнэ. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэл эрмэлзэлтэй байвал боломжийн хугацаанд нэмэлт гэрээг бичгээр үйлдэн эрх бүхий хүмүүсээр баталгаажуулна.
- 10.3 Энэхүү гэрээнд гагцхүү Талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 10.4 Энэхүү гэрээнд гарын үсэг зурсан этгээдийг тухайн талаа төлөөлөх бүрэн эрхтэй хэмээн үзэх бөгөөд төлөөлөх эрхгүй этгээдээр гарын үсэг зуруулснаас үүдэн гарах аливаа эрсдэл, хариуцлагыг тухайн төлөөлүүлсэн тал бүрэн хариуцна.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

- 10.5 Гэрээнд дараах Хавсралтууд байх ба Тэдгээр нь гэрээний салшгүй хэсэг болно.
- a) Зөвлөх үйлчилгээний тендерийн ажлын даалгавар
 - b) Захиалгын хуудасны загвар
 - c) Үйлчилгээний үнийн санал
- 10.6 Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэн, Захиалагч 1 хувь, Гүйцэтгэгч 1 хувь тус бүр хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НЭР: О. ДҮҮРИЙМАА

**АЛБАН ТУШААЛ: ХҮНИЙ НӨӨЦИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ**



ХАРИЛЦАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НЭР: З.ЭРДЭНЧУЛУУН

**АЛБАН ТУШААЛ: ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА**

ГАРЫН ҮСЭГ:

НЭР: Б.УНДАРМАА

**АЛБАН ТУШААЛ: ЗУХАГ-ЫН ХҮНИЙ
НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН**

ГАРЫН ҮСЭГ:

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.